



МОНГОЛЫН АВТОТЭЭВЭРЧДИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Зам, тээврийн хөгжлийн яам, Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо хооронд байгуулсан “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгэх гэрээ”-ний 4.1 дэх заалт, Холбооны дүрмийн 8.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зөвлөх болон мэргэшсэн инженерийн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг сургалтын менежер Л.Сэрээтэр-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д. НАРАНПҮРЭВ



ЗӨВЛӨХ БОЛОН МЭРГЭШСЭН ИНЖЕНЕРИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмийн зорилго нь Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо (цаашид “Холбоо” гэх)–ны дэргэдэх Зам, тээврийн ажиллагсдын мэргэжлийн боловсролын институт (цаашид “Институт” гэх)-ээс автотээврийн салбарын зөвлөх болон мэргэшсэн инженерийн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Автотээврийн салбарын мэргэжилтэнийг сургах, мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаа нь тэдний мэдлэг, ур чадвар, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бүтээл, туршлагыг үнэлэх, ажил үйлчилгээний бүтээмж, чанарыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

1.3. Институт нь энэхүү журмаас гадна сургалтын үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомж, боловсролын болон тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Холбооны бодлого, чиглэл, шийдвэрийг дагаж мөрдөнө.

ХОЁР. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

2.1. Автотээврийн салбарын мэргэжилтний мэргэжлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүргийг Холбооны дэргэдэх салбарын мэргэжилтний мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус “Мэргэжлийн зөвлөл” эрхэлнэ.

2.2. Мэргэжлийн зөвлөл нь салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, бууруулах, хүчингүй болгох үйл ажиллагааг энэхүү журмын дагуу зохион байгуулах, хэлэлцэж шийдвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.3. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Холбооны гүйцэтгэх захирлын тушаалаар батална.

2.4. Мэргэжлийн зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд Зам, тээврийн хөгжлийн яам, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо ТББ, Авто инженерүүдийн холбоо ТББ, Механик тээврийн сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Батлан хамгаалахын их сургуультай зөвшилцсөний дагуу холбогдох газар, тэнхимийн төлөөллийг оролцуулна.

2.5. Мэргэжлийн зөвлөлийг Зам, тээврийн хөгжлийн яамны зөвшилцсөн төлөөлөл даргалж, Холбооны дэргэдэх Зам, тээврийн ажиллагсдын мэргэжлийн боловсролын институтын сургалтын менежер нь уг зөвлөлийн болон шалгалтын комиссын нарийн бичгийн даргаар ажиллана.

2.6. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн хурлын ирцийг бүрдүүлэх, хурлын тэмдэглэл хөтлөх, гаргасан дүгнэлтийг баталгаажуулах, холбогдох газар, харьяа байгууллагад хүргүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.7. Мэргэжлийн зөвлөлийн хурал нь 70 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр хуралдаж олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.8. Мэргэжлийн зөвлөлийн гаргасан шийдвэрийг Холбооны гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна.

2.9. Мэргэжлийн зөвлөл дор дурьдсан эрх, үүрэгтэй. Үүнд:

- 2.9.1 Салбарын мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох, сунгах, ахиулах, цуцлах, хүчингүй болгох;
- 2.9.2 Мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг горилогчдод зориулсан сургалтын хөтөлбөрийг баталж хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 2.9.3 Мэргэжлийн зөвлөл нь Шалгалтын комиссыг Мэргэжлийн зөвлөлийн нэг гишүүн ахлуулан 3 буюу түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй томилох;
- 2.9.4 Холбогдох дүрэм, журмыг чанд баримтлан ашиг сонирхлын зөрчилгүйгээр, үнэнч шударга ажиллах;
- 2.9.5 Институтын сургалтын үйл явцтай танилцах, хяналт тавих, сургалтын тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 2.9.6 Сургалт, шалгаруулалттай холбогдон гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх.
- 2.10. Институт дор дурьдсан эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 2.10.1 Сургалтанд хамрагдахаар хүсэлт гаргасан бүртгүүлэгчдийн бүрдүүлсэн материалыг мэргэжлийн зөвлөлийн даргаар хянуулах;
 - 2.10.2 Зохион байгуулах сургалт нь салбарын мэргэжилтний мэргэшлийн зэрэгтэй уялдаж, салбарын эрэлт, хэрэгцээнд тулгуурласан, агуулгын хувьд суралцагсдад онолын болон дадлагын мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн байна;
 - 2.10.3 Сургалтыг зориулалтын анги танхимд зохион байгуулах, сургалтын материал, тоног төхөөрөмжөөр хангах;
 - 2.10.4 Мэргэжлийн зөвлөлөөс ирүүлсэн санал, зөвлөмж, шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах;
 - 2.10.5 Сургалтын талаар судалгаа хийж, дотоод хяналт тавих, сургалтанд хамрагдагчдаас сургалтын чанар, хүртээмжийн талаар санал асуулга авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;
 - 2.10.6 Сургалтын хөтөлбөр боловсруулж мэргэжлийн зөвлөлөөр батлуулж хэрэгжүүлэх;
 - 2.10.7 Зохион байгуулсан сургалтын агуулгаар зургаан хувилбараар шалгалтын тест боловсруулж бэлтгэнэ;
 - 2.10.8 Шаардлага хангасан сургалтын тайланг шалгалт авсанаас хойш ажлын 3 өдөрт багтаан Мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх;
 - 2.10.9 Сургалтын тайлан, дүгнэлтээ хагас жил тутамд Мэргэжлийн зөвлөлд тайлагнаж байх;
 - 2.10.10 Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан болон мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтний талаарх нэгдсэн мэдээллийн санг хөтөлж, мэдээлэл, лавлагаагаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэх;
 - 2.10.11 Мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж Мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх;
 - 2.10.12 Батлагдсан хөтөлбөрийн дагуу хичээл заах багш нартай гэрээ байгуулж ажиллах бөгөөд багш нар хөтөлбөрийн агуулгаар сургалтын болон шалгалтын материал боловсруулна;
 - 2.10.13 Сургалттай холбоотой бичиг баримт /хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөө, суралцагчдын судалгаа, шалгалтын материал, санал хүсэлт г.м/-ыг архивын нэгж болгон 10 жил хадгалах;
 - 2.10.14 Салбарын мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэх сургалтын чиглэлээр мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах.

ГУРАВ. Мэргэжлийн зэрэг горилогчид тавих шаардлага

- 3.1. Зэрэг горилогч нь автотээврийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна.
- 3.2. Зөвлөх инженерийн зэрэг горилогч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.2.1 Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн инженерийн зэргийг хоёр удаа сунгуулсан мэргэшсэн инженерийн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ тасралтгүй ажилласан байх;
 - 3.2.2 Бүтээл, мэргэжил дээшлүүлэх талаар зохих шаардлагыг хангасан (шинэ бүтээл, ашигтай загвар, патентын гэрчилгээ, техник технологи, норм, норматив, томоохон төсөл хөтөлбөрт оролцсон 3 хүртэл бүтээл) байх, 2-оос доошгүй бүтээл үйлдвэрлэлд нэвтэрсэн байх;
 - 3.2.3 Төсөл удирдах арга барил, судалгаа шинжилгээний ажлын чиглэлийг тодорхойлж үнэлгээ, дүгнэлт гаргах чадвартай, мэргэжилтнүүдийг сургах, дадлагажуулах чадвар эзэмшсэн байх.
- 3.3. Мэргэшсэн инженерийн зэрэг горилогч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.3.1 Бакалаврын зэрэгтэй бол мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, магистрын зэрэгтэй мэргэжлээрээ 4-өөс доошгүй жил ажилласан байх;
 - 3.3.2 Бүтээл, мэргэжил дээшлүүлэх талаар зохих шаардлагыг хангасан (шинэ бүтээл, ашигтай загвар, патентын гэрчилгээ, техник технологи, норм, норматив, томоохон төсөл хөтөлбөрт оролцсон 2-оос доошгүй бүтээл) байх.
- 3.4. Зэрэг горилогч нь сургалтад хамрагдахаас өмнө дараах баримт бичгийг бүрдүүлж институтэд ирүүлнэ. Үүнд:
 - 3.4.1 Зөвлөх болон мэргэшсэн инженерийн сургалтанд хамрагдахыг хүссэн өргөдөл; (хавсралт 1)
 - 3.4.2 Мэргэшлийн зэрэг горилох, сунгах мэргэжилтний анкет; (хавсралт2)
 - 3.4.3 Ажлын газрын тодорхойлолт;
 - 3.4.4 3×4 хэмжээтэй цээж зураг 1 хувь;
 - 3.4.5 Мэргэжлийн дипломын хуулбар эх хувийн хамт;
 - 3.4.6 Нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар;
 - 3.4.7 Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж авсан үнэмлэх, гэрчилгээний хуулбар;
 - 3.4.8 Ажил олгогчоос гадна тухайн мэргэжлийн чиглэлээр зөвлөх инженер зэрэгтэй мэргэжилтнээр баталгаажуулсан бүтээлийн тайлан (хавсралт3)– г гаргаж, боловсруулсан норм, дүрэм, стандарт, бичсэн ном, гарын авлага, нийтлэл, бүтээлийн фото болон видео хэлбэр, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар, гүйцэтгэсэн, боловсруулахад оролцсон зураг төсөл, төсвийн талаарх материалуудыг хавсаргах.

ДӨРӨВ. Мэргэжлийн зэрэг олгох сургалт, шалгалтын үйл ажиллагаа

- 4.1. Сургалт эхлэхээс өмнө зэрэг горилогчийн талаарх мэдээллийг Мэргэжлийн зөвлөлийн даргад хянуулсны үндсэн дээр сургалтыг эхлүүлнэ.
- 4.2. Шалгаруулалтыг мэргэжилтний мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадвар, бүтээл, туршлагыг магадлан үнэлэх замаар гүйцэтгэнэ.

4.3. Мэргэжилтний мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадварыг шалгалтаар, бүтээл туршлагыг зохих тодорхойлолт, бүтээлийн тайланг магадлан шалгах замаар тодорхойлно.

4.4. Мэргэжлийн шалгалтыг Мэргэжлийн зөвлөлийн томилсон шалгалтын комисс зохих журмын дагуу зохион байгуулна.

4.5. Мэргэжлийн шалгалт дараах үе шаттай байна. Үүнд:

4.5.1. Нэгдүгээр шат. Ерөнхий мэдлэгийн шалгалт;

4.5.2. Хоёрдугаар шат. Мэргэжлийн шалгалт;

4.5.3. Гуравдугаар шат. Сэдвийн хамгаалалт.

4.6. Зэрэг горилогч нь сургалтын хөтөлбөрт бүрэн хамрагдсан байх бөгөөд мэргэшсэн инженерийн зэрэг горилогч нь зөвхөн нэг, хоёрдугаар шатны шалгалтанд, зөвлөх инженерийн зэрэг горилогч нь гурван шатны бүх шалгалтанд хамрагдана.

4.7. Ерөнхий мэдлэгийн шалгалтанд зэрэг горилогчийн бүтээлийн тайлангийн үнэлгээ болон тестеер авсан шалгалт хамаарна.

4.8. Бүтээлийн тайланг хянан магадалж үнэлэх бол ерөнхий мэдлэгийн шалгалтыг их дээд сургуулийн сургалтын бүрэн программын хэмжээнд хураангуй байдлаар тестээр авна.

4.9. Зэрэг горилогч нь ерөнхий мэдлэгийн шалгалтад авбал зохих нийт оноог авсан тохиолдолд шалгалтад тэнцсэнд тооцож дараагийн шатны шалгалтад хамрагдана.

4.10. Мэргэжлийн шалгалт нь тухай сургалтын хөтөлбөрийн хүрээнд тест болон бичгээр авна.

4.11. Мэргэжлийн шалгалтад авбал зохих нийт оноог авсан тохиолдолд тэнцсэнд тооцно.

4.12. Шалгалтын комиссын шийдвэрийг Мэргэжлийн зөвлөл хэлэлцээд суралцагч нарт гэрчилгээ (хавсралт4), дардас (хавсралт5) олгох эсэхийг шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг гүйцэтгэх захиралын тушаалаар баталгаажуулна.

ТАВ. Зэргийг сунгах, ахиулах, цуцлах

5.1. Зөвлөх инженерийн зэргийг сунгах

5.1.1. Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө институтэд ирүүлнэ;

5.1.2. Мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт заавал бие даан боловсруулсан, хянан тохиолдуулсан, 2-оос доошгүй санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байх;

5.1.3. Зэргээ сунгуулах хүсэлт гаргагчаас тайлан хамгаалалт хийлгүүлж, шалгалт авах ба тайлан хамгаалалт, шалгалт тус бүрт 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлбэл зэргийг сунгах саналыг зөвлөлд оруулж шийдвэрлүүлнэ;

5.1.4. Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь 5 жил тутамд зэргээ сунгаж баталгаажуулах ба 3 дах сунгалтаас гэрчилгээнд хугацаа заахгүй.

5.2. Мэргэшсэн инженерийн зэргийг сунгах

5.2.1. Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө институтэд ирүүлнэ;

- 5.2.2. Мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт боловсруулахад заавал оролцсон, хянан тохиолдуулсан, санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байх;
- 5.2.3. Мэргэшсэн зэргийн хугацаа сунгуулахад ажлаа шалгалтын комиссоод тайлагнах ба 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана;
- 5.2.4. Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь 3 жил тутамд зэргээ сунгаж баталгаажуулах ба 4 дэх сунгалтаас гэрчилгээнд хугацаа заахгүй.
- 5.3. Мэргэшсэн зэргээ зөвлөх зэрэгт ахиулах
 - 5.3.1. Мэргэшсэн инженерийн сургалтанд 2 удаа хамрагдсан байна;
 - 5.3.2. Мэргэшсэн зэргээ зөвлөх зэрэгт ахиулах хүсэлт гаргасан бол зэрэг сунгах бүтээлийн тайлан хамгаалалтад орж тэнцсэн байна;
 - 5.3.3. Ерөнхий мэдлэгийн болон Мэргэжлийн шалгалтад авбал зохих нийт онооны 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байна;
 - 5.3.4. Тайлан, сэдвийн хамгаалалтад 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байна;
 - 5.3.5. Мэргэжлийн чиглэлээр 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт заавал бие даан боловсруулсан, хянан тохиолдуулсан, 2-оос доошгүй санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байх.
- 5.4. Зөвлөх болон мэргэшсэн инженерийн зэргийг цуцлах
 - 5.4.1. Зэргээ цуцлуулах хүсэлтийг мэргэжилтэн өөрөө гаргасан;
 - 5.4.2. Зэргийн хугацаа хэтэрсэн, зэрэг авсан хугацаанд мэргэжлээрээ ажиллаагүй;
 - 5.4.3. Шалгаруулалтад хугацаандаа ороогүй, тэнцээгүй;
 - 5.4.4. Мэргэжлийн алдаа дутагдал гаргасан нь нотлогдсон;
 - 5.4.5. Бүтээлээ худал мэдүүлсэн, бусдын бүтээлийг худал баталгаажуулсан;
 - 5.4.6. Мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор гэмт хэрэгт шийтгүүлсэн.
- 5.5. Мэргэжлийн хүрээний чиглэлээр докторын зэрэг хамгаалсан тохиолдолд Зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн мэргэжлийн болон сэдвийн хамгаалалтын шалгалтаас чөлөөлж хугацаагүйгээр зэргийг олгоно.